



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Цахир сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/123/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор Л.Соёлмөнх Утас: 703333019 Цахим хаяг: soyolmunkhl@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
4.3 Албан шаардлага	15
4.4 Зөвлөмж.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ЦАХИР СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГА Д.ЧИНГЭС ТАНАА

2022.02.15 № 09

танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Цахир сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Цахир сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Д. Чингэс Танаа* Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	16,583,727.00	18,268,550.00
35	БАРАА МАТЕРИАЛ	16,583,727.00	18,268,550.00
35100	Түүхий эд материал	7,353,150.00	7,353,150.00
35110	Тусгай зориулалттай материал	7,353,150.00	7,353,150.00
35400	Хангамжийн материал	9,230,577.00	10,915,400.00
35410	Бичиг хэргийн материал	627,600.00	415,000.00
35420	Аж ахуйн материал	8,602,977.00	8,925,400.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	1,575,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	546,241,032.72	545,493,255.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	546,241,032.72	545,493,255.86
39200	Биет хөрөнгө	544,241,032.72	543,493,255.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	524,043,554.69	524,043,554.69
39202	Хуримтлагдсан элэгдэл	-15,633,570.03	-22,213,535.31
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	17,455,314.00	22,917,174.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-17,190,302.27	-15,260,880.23
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,303,306.00	23,303,306.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,965,880.67	-16,524,973.95
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,781,000.00	14,781,000.00
39217	Ном	12,447,611.00	12,447,611.00
39300	Биет бус хөрөнгө	2,000,000.00	2,000,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	2,000,000.00	2,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	562,824,759.72	563,761,805.86
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	562,824,759.72	563,761,805.86
51	Засгийн газрын хувь оролцоо	562,824,759.72	563,761,805.86
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	349,121,607.80	349,121,607.80
51200	Хуримтлагдсан үр дүн	75,514,496.47	76,451,542.61
51210	Өмнөх үеийн үр дүн	75,220,576.04	75,514,496.47
51220	Тайлант үеийн үр дүн	293,920.43	937,046.14
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	138,188,655.45	138,188,655.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	562,824,759.72	563,761,805.86

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	93,855,100.00	98,679,150.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,666,300.00	7,946,550.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,666,300.00	7,946,550.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,666,300.00	7,946,550.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	666,300.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,000,000.00	7,946,550.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	85,188,800.00	90,732,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	85,188,800.00	90,732,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	85,188,800.00	90,732,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	93,459,427.35	97,742,103.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	93,459,427.35	97,742,103.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	90,721,369.57	96,588,486.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	66,504,909.22	69,609,800.00
210101	Үндсэн цалин	66,504,909.22	69,609,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,461,553.00	8,829,082.44
210201	Тэтгэврийн даатгал	5,279,930.00	6,292,528.71
210202	Тэтгэмжийн даатгал	476,200.00	512,793.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	403,057.00	539,669.52
210204	Ажилгүйдлийн даатгал	122,633.00	134,917.39
210205	Эрүүл мэндийн даатгал	1,179,733.00	1,349,173.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,800,000.00	6,225,000.00
210301	Гэрэл, цахилгаан	828,492.00	792,810.00
210302	Түлш, халаалт	4,941,508.00	5,332,190.00
210303	Цэвэр, бохир ус	30,000.00	100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	787,700.00	1,218,700.00
210401	Бичиг хэрэг	194,500.00	187,400.00
210402	Тээвэр, шатахуун	296,500.00	296,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	50,000.00	69,500.00
210404	Ном, хэвлэл	18,000.00	18,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	228,700.00	647,300.00
2105	Нормативт зардал	39,600.00	225,077.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	39,600.00	225,077.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	846,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	416,000.00
210604	Урсгал засвар	0.00	430,000.00
2107	Томилолт, зочны зардал	70,500.00	70,500.00
210702	Дотоод албан томилолт	70,500.00	70,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	298,480.00	870,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	208,000.00	790,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000.00	80,000.00
210807	Газрын төлбөр	10,480.00	0.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,758,627.35	8,694,326.86
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,758,627.35	8,694,326.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,738,057.78	1,153,617.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	966,300.00	438,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	966,300.00	438,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,771,757.78	714,817.56
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,771,757.78	714,817.56
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	395,672.65	937,046.14
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	101,752.22	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	101,752.22	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	293,920.43	937,046.14

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр / Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	349,121,607.80	138,188,655.45	75,220,576.04	562,530,839.29
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	349,121,607.80	138,188,655.45	75,220,576.04	562,530,839.29
3	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	293,920.43	293,920.43
4	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	349,121,607.80	138,188,655.45	75,514,496.47	562,824,759.72
5	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	349,121,607.80	138,188,655.45	75,514,496.47	562,824,759.72
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	349,121,607.80	138,188,655.45	75,514,496.47	562,824,759.72
7	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	937,046.14	937,046.14
8	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	349,121,607.80	138,188,655.45	76,451,542.61	563,761,805.86

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	85,855,100.00	90,732,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	666,300.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	666,300.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	666,300.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	666,300.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	85,188,800.00	90,732,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	85,188,800.00	90,732,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	85,188,800.00	90,732,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	85,855,100.00	90,732,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	85,855,100.00	90,732,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	83,117,042.22	89,578,982.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	66,609,799.22	69,609,800.00
210101	Үндсэн цалин	66,609,799.22	69,609,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,356,663.00	8,829,082.44
210201	Тэтгэврийн даатгал	5,079,578.00	6,130,734.80
210202	Тэтгэмжийн даатгал	571,659.00	674,586.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	403,054.00	539,669.52
210204	Ажилгүйдлийн даатгал	122,636.00	134,917.39
210205	Эрүүл мэндийн даатгал	1,179,736.00	1,349,173.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,800,000.00	7,800,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,700,000.00	1,700,000.00
210302	Түлш, халаалт	4,000,000.00	6,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	618,100.00	618,100.00
210401	Бичиг хэрэг	66,500.00	66,500.00
210402	Тээвэр, шатахуун	296,500.00	296,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	69,500.00	69,500.00
210404	Ном, хэвлэл	66,300.00	66,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	119,300.00	119,300.00
2105	Нормативт зардал	49,000.00	49,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	49,000.00	49,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000.00	100,000.00
210604	Урсгал засвар	100,000.00	100,000.00
2107	Томилолт, зочны зардал	70,500.00	70,500.00
210702	Дотоод албан томилолт	70,500.00	70,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,512,980.00	2,502,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,422,500.00	2,422,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000.00	80,000.00
210807	Газрын төлбөр	10,480.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,738,057.78	1,153,617.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	966,300.00	438,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	966,300.00	438,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,771,757.78	714,817.56
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,771,757.78	714,817.56

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	90,732,600.00	90,017,782.44	714,817.56	99.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	90,732,600.00	90,017,782.44	714,817.56	99.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	90,293,800.00	89,578,982.44	714,817.56	99.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	69,609,800.00	69,609,800.00	0.00	100.00
210101	Үндсэн цалин	69,609,800.00	69,609,800.00	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,397,300.00	8,829,082.44	568,217.56	93.95
210201	Тэтгэврийн даатгал	6,612,900.00	6,130,734.80	482,165.20	92.71
210202	Тэтгэмжийн даатгал	696,100.00	674,586.91	21,513.09	96.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	556,900.00	539,669.52	17,230.48	96.91
210204	Ажилгүйдлийн даатгал	139,200.00	134,917.39	4,282.61	96.92
210205	Эрүүл мэндийн даатгал	1,392,200.00	1,349,173.82	43,026.18	96.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,800,000.00	7,800,000.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	1,700,000.00	1,700,000.00	0.00	100.00
210302	Түлш, халаалт	6,000,000.00	6,000,000.00	0.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	100,000.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	618,100.00	618,100.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	66,500.00	66,500.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	296,500.00	296,500.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	69,500.00	69,500.00	0.00	100.00
210404	Ном, хэвлэл	66,300.00	66,300.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	119,300.00	119,300.00	0.00	100.00
2105	Нормативт зардал	49,000.00	49,000.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	49,000.00	49,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000.00	100,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	100,000.00	100,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	70,500.00	70,500.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	70,500.00	70,500.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,649,100.00	2,502,500.00	146,600.00	94.47
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,422,500.00	2,422,500.00	0.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000.00	80,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	146,600.00	0.00	146,600.00	0.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	438,800.00	438,800.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	438,800.00	438,800.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	438,800.00	438,800.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	90,732,600.00	90,017,782.44	714,817.56	99.21
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	90,732,600.00	90,017,782.44	714,817.56	99.21
320001	Орон нутгийн төсвөөс	90,732,600.00	90,017,782.44	714,817.56	99.21
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	19.00	19.00	0.00	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	9.00	9.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	3.00	3.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	0.00	100.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Цахир сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Соёлмөнх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Цахир сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18 - ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Цахир сумын Соёлын төв нь ард иргэдэд соёл урлаг, олон нийтийн арга хэмжээг зөв боловсон хүргэж, хүүхэд залуучуудын авъяас билгийг нээн илрүүлж, олныг хүртээл болгох мөн соёлын үйлчилгээний цар хүрээг өргөтгөж соёлын стандартын шаардлагыг хангах зорилготой соёл урлагын үйл ажиллагаа явуулдаг, орон нутгийн төсвөөс санхүүждэг, төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд дараах зорилтуудыг тавин ажилласан байна. Үүнд:

- Соёлын төвийг техник, тоног төхөөрөмж, хөгжмийн зэмсгээр хангах
- Соёлын төвөөс орон нутгийн хүн амд хүргэх соёл, олон түмний ажилд иргэдийг өргөнөөр хамруулах
- Соёл урлагийн үзвэр үйлчилгээг сайжруулах, давтамж чанарыг өсгөх, урлагаар үйлчлүүлэх иргэдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх
- Соёл урлагийн байгууллагад ажиллагсдыг мэргэжил дээшлүүлэх сургалт семинарт хамруулах
- Эх хэл, үндэсний зан заншил, соёлын өвийг хүүхэд багачуудад залууст уламжлуулах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх талаар олон талт ажлыг зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой Соёлын тухай хуульд 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр өөрчлөлт орсон байна. Харин санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн Тэтгэврийн даатгал-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, Тэтгэврийн даатгал-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, Шимтгэлийн дүн-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.7" гэснийг "11.7" гэж, Шимтгэлийн дүн-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.5" гэснийг "11.5" гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн "12.5 хувиас" гэснийг "11.5 хувиас" гэж тус тус өөрчилсүгэй” гэснээр даатгуулагч болон ажил олгогчоос төлөх НДШ тус бүр 1%-аар буурч өөрчлөгдсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагаанд дотоод хяналтын нэгжээс санхүүгийн гүйлгээ, шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулсан талаар, няравын тайлан, анхан шатны баримтын бүрдүүлэлтийг, эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалтын талаар нийт 3 чиглэлээр дотоод хяналт шалгалтыг үүрэг даалгавар өгч ажилласан байна.

Цахир сумын Соёлын төв нь Архангай аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/841 дүгээр тушаалаар батлагдсан Соёлын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд бусад эрх бүхий байгууллагаас болон хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Цахир сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 90.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 0.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 0.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 1.1 сая төгрөгөөр буюу 0.2 хувиар өссөн материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Бараа материал	16.5	16.7	0.2	1.2
Үндсэн хөрөнгө	546.2	547.1	0.9	0.1
Нийт хөрөнгө	562.8	563.9	1.1	0.2
Өр төлбөр	-	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	562.8	563.9	1.1	0.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	562.8	563.9	1.1	0.2

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 1.2 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 16.5 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 8.2 төгрөг нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 8.0 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 16.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 0.2 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 594.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 1.5 сая төгрөгөөр, БСШУЯ-наас үнэ төлбөргүй хүлээн авсан 7.9 сая төгрөг нийт 9.4 сая төгрөгөөр нэмэгдэж, аймгийн ОНӨГ-ын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 583 тоот албан бичгээр байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн саналыг үндэслэн зөвшөөрөл олгосны дагуу 2.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлаж данснаас хассан, тайлант хугацаанд байгуулсан 53.8 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч, 547.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Өр төлбөр данс нь тайлант хугацаанд өр авлагагүй ажилласан байна.
- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүн 1.1 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/ төгрөг /

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	85,188,800.00	90,732,600.00	5,543,800
Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	0.00	0
Татварын бус орлого	8,666,300.00	7,946,550.00	-719,750
Үйл ажиллагааны орлого	93,855,100.00	98,679,150.00	4,824,050
Цалин, шимтгэлийн зардал	73,966,462.22	78,438,882.44	4,472,420
Бусад бараа үйлчилгээний зардал	9,435,857.78	9,738,894.56	303,037
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	298,480.00	870,000.00	571,520
Бараа үйлчилгээний бусад зардал	9,758,627.35	8,694,326.86	-1,064,300
Үйл ажиллагааны зардал	93,459,427.35	97,742,103.86	4,282,677
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	395,672.65	937,046.14	541,373
Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	101,752.22	0.00	-101,752
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	293,920.43	937,046.14	643,126

Цахир сумын Соёлын төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 4.8 сая төгрөгөөр буюу 5.1 хувиар өссөн нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд 2021 онд батлагдсан зардлыг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 98.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 7.4 сая төгрөгөөр бууруулж, нийт зардлыг 90.7 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 90.7 сая төгрөгийн төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 90.7 сая төгрөгийн орлого, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлснээс 90.0 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулан, 0.7 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас 0.6 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 0.1 сая төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд “Ковид 19” цар тахалтай холбоотойгоор соёлын үйлчилгээ, олон нийтийн ажлыг хориглосон тул нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус соёлын төв нь 2021 онд шинээр батлагдсан Ковид-19 цар тахлын үед улс, аймаг сумын онцгой комиссоос аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгааны дагуу соёл урлагийн үйлчилгээг хориглосны улмаас соёл урлагийн болон олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 5 үндсэн зорилтын хүрээнд 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 93.0 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 90.7 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 90.1 сая төгрөгийг зарцуулж, 99.2 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:

- Өндөр насны тэтгэвэр тогтоолгож ажлаас чөлөөлөгдсөн албан тушаалтан байхгүй.

- Урсгал зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.

2. Суудлын автомашингүй.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэл байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүлжээ.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Цахир сумын Соёлын төв нь тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийг шалгахад нийт 151 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан бөгөөд хугацаа хоцорсон мэдээлэл байхгүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 6.0 сая төгрөгийн 8 орлогын, 6.8 сая төгрөгийн 8 зарлагын нийт 12.8 сая төгрөгийн 16 мэдээллийг Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулахаас 8.4 сая төгрөгийн 13 мэдээллийг ил тод байршуулаагүй байна.

Иймд аудитаас Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-6.10-д заасан “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ ...”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг мэдээллэх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлжээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд батлагдсан төсвөөс 0.1 сая төгрөгийг төвлөрүүлэн 1.3 хувийг хэмнэж, 8.7 хувийн буюу 0.9 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

Иймд аудитаас Засгийн газрын 43-р тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүлжээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн тувшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4.2 сая төгрөгийн түлшний үнийн хөнгөлөлтийг илүү олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлж, зөрчлийг таслан зогсоож ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг анхан шатны баримтад үндэслэн нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1.4 сая төгрөгийн алдааг залруулж, 0.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 0.1 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар бараа материалын шинж чанартай 1.4 сая төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгөд бүртгэснийг аудитын явцад залруулж, бараа материалын дансанд тусгуулан санхүүгийн тайланд залруулга хийлээ.

4.2 Албан шаардлага

Түлш халаалтын зардлыг анхан шатны баримтаар тулган шалгахад түлшний зарцуулагдаагүй үлдэгдэл 0.8 сая төгрөгийн нүүрсний үлдэгдэлтэй байгаа зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийг хэмнэлтийн Засгийн газрын 43 дугаар тогтоол болон Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, Албан шаардлага өгөх.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

4.3.1. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Засгийн газрын 43-р тогтоолын дагуу албан томилолт, тээвэр шатахууны зардлыг түүвэрлэн шалгахад 0.07 сая төгрөгийн томилолтын, 0.09 сая төгрөгийн шатахууны анхан шатны баримтын бүрдэл дутуу нийт 0.16 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 2019 оны ЗГ-ын 6 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид нөхөн олговор олгох журмын 2.1 дэх заалтуудтай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Сангийн сайдын 347 дугаар тушаалын дагуу нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдлийг хангуулж ажиллах зөвлөмжийг өгч байна.

Зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Цахир сумын Соёлын төв	3	2.3	1	1.4	0	0	1	0.8	1	0.1
Дүн		3	2.3	1.4	1.4	0	0	1	0.8	1	0.1
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Цахир сумын Соёлын төв	2	0.9	0	0	0	0	1	0.9	1	0
Дүн		2	0.9	0	0	0	0	1	0.9	1	0
Нийт дүн		5	3.2	1	1.4	0	0	2	1.7	2	0.1